БАТЛАВ
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
. . . . . С.ТӨМӨРДУЛАМ
2022 оны 05 дугаар сарын 17

ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 05 дугаар сарын 17ны Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр:	Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага
Ажил гүйцэтгэх хугацаа:	Хуанлийн 90 хоног

ҮНДЭСЛЭЛ:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.6. дахь заалтад тусгасан Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлэх зорилт, Хотын стандарт, хяналтын газрын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалын дагуу "Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" баримт бичгийг боловсруулахаар арга хэмжээ төлөвлөгдсөн нь удирдамж арга зүйн баримт бичгүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах үндэслэл болно.

ЗОРИЛГО:

Нийслэлийн хэмжээнд оршуулгын газруудын орчны төлөвлөлт, аюулгүй байдлыг хангах, түүнд шаардлагатай хотын стандартыг бий болгох зорилготой.

АГУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Хотын стандартын баримт бичигт дараах агуулгыг тусгасан бөгөөд сэдвийн онцлогт тохирсон зурган мэдээлэлтэй байна. Үүнд:

№	АГУУЛГЫН НЭР	АГУУЛГЫН ХҮРЭЭНД ШААРДЛАГАТАЙ ТАЙЛБАР МЭДЭЭЛЭЛ
1	Хамрах хүрээ	Хотын стандартыг даган мөрдөх хамрах хүрээг тодорхойлон бичсэн байна.
2	Норматив эшлэл	Тухайн хотын стандартын баримт бичигт эшлэл хийсэн хууль, дүрэм, журам зэргийг багтаасан байна.
3	Оршуулгын газрын орчны ерөнхий шаардлага	Энэ бүлэгт дараах мэдээллийг бүрэн багтаасан байна. Үүнд:

		- Оршуулгын газрын төлөвлөлтөд тавигдах шаардлага. /хашаа, хайс, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, оршуулгын төрөл, ангилал, чандар, эко оршуулга/; - Модлог ургамлын эгнээ хоорондын төлөвлөлт; - Хөшөө дурсгалын төлөвлөлт; - Гэрэлтүүлгийн төлөвлөлтийн шаардлага; - Орц, гарцын төлөвлөлтийн шаардлага; - Ногоон байгууламжийн төлөвлөлтийн шаардлага; - Хяналтын системийн төлөвлөлтийн шаардлага.
4	Эрүүл ахуйн шаардлага	Тухайн газрын онцлог талыг харгалзан тусгасан стандартын заалтуудыг багтаасан байна. Үүнд: - Халдваргүйжүүлэлт; - Онцгой хог хаягдлын менежмент гэх мэт оршуулгын газрын орчинд дагаж мөрдөх шаардлагатай эрүүл ахуйн шаардлагыг бүрэн багтаасан байна.
5	Оршуулгын газрыг хаах шаардлага	Оршуулгын газрыг ямар тохиолдолд хаах болсон гэж үзэх үндсэн шаардлагуудыг тусгасан байна.
6	Оршуулгын газрыг нүүлгэн шилжүүлэх шаардлага	Нүүлгэн шилжүүлэх үндсэн нөхцөл, түүнтэй холбоотойгоор тусгай шаардлага, онцлог анхаарах зүйлсийг бүрэн тусгасан байна.
7	Онцгой анхаарах болон хориглох шаардлагууд	Оршуулгын газрын орчинд хориглох зүйлсийг сайтар тусган, аюулгүй байдлыг хангуулах чиглэлд хэм хэмжээ тогтоохуйц заалтуудыг боловсруулах
8	Шалгах хуудас	Шинээр төлөвлөх, ашиглалтыг үнэлэхэд зориулсан шалгах хуудсыг боловсруулсан байна.

Дээрх мэдээллийг үндэсний стандарт, норм дүрэм, олон улсын стандарттай нийцүүлэн, эх сурвалжийг бүрэн дурдсан байна.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Хотын стандартын баримт бичиг нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хууль, дүрмийг уншигчийн танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, оновчтой томьёолсон байх;
- Баримт бичгийн агуулгыг тодруулсан зураг боловсруулан оруулсан байх;
- Тухайн баримт бичигт анхаарах зүйлсийг тусган шалгах хуудас боловсруулах;
- Гадаад орны туршлага судлан манай улсад нутагшуулж болох шинэлэг санааг тусгасан байх;
- Баримт бичиг нь тодорхой хэм хэмжээг тодорхойлсон байх;

MNS 0001-2:2006 Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрмийн дагуу баримт бичгийг боловсруулна.

Хэл найруулгад тавигдах шаардлага:

- Хэл найруулга нь зөв оновчтой байх;
- Нэр томьёоны тайлбартай байх;
- Монгол хэлний зөв бичих дүрмийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Тайланг 4 хувь хийж, цаасан болон CD хуулж ирүүлэх;

- Хэвлэлийн эх бэлтгэлийг хийсэн байх;
- Баримт бичгийн зурагт тавигдах шаардлага, үзүүлэлтийг оруулах.

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Баримт бичиг боловсруулах ажлыг захиалагч талд дараах үе шаттай тайлагнан ажиллана. Үүнд:

1. Баримт бичгийн эхний хувилбар боловсруулах;
   - Гэрээ байгуулагдсанаас хойш 21 хоногийн дотор хотын стандартын баримт бичгийн эхний хувилбарыг захиалагч талд танилцуулан хэлэлцүүлнэ.
2. Захиалагчийн саналыг тусган засварласан дундын тайланд сонирхогч тал болох доорх байгууллагуудаас санал авах бөгөөд эхний танилцуулгаас хойш 21 хоногийн дотор уг ажлыг эхлүүлсэн байна. Үүнд:
   А. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба;
   Б. Нийслэлийн цагдаагийн газар;
   В. Нийслэлийн онцгой байдлын газар;
   Г. Оршуулгын газрын холбоо ТББ.
3. Саналын нэгтгэл хийж, тэмдэглэл хөтлөн шаардлагатай засварыг баримт бичигт тусгасан байх
4. Хотын стандартын баримт бичгийн эцсийн хувилбарыг гэрээнд заагдсан хугацаанд захиалагчид эцэслэн хүлээлгэн өгөх.

Зөвлөхөд тавигдах шаардлага:

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх нь Хот төлөвлөлт, эсхүл байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд аж ахуйн нэгж байгууллага, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, шаардлага хангасан мэргэжилтнүүдээс бүрдсэн баг байна;
- Стандартын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх;
- Монгол, англи хэлний бичгийн өндөр ур чадвартай байх.

ЗӨВЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА: Зөвлөх баг нь голлох 4 мэргэжилтэнтэй байх ба багт ажиллах хүний тоо үүгээр хязгаарлагдахгүй. Багийн голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

№	Мэргэжил	Мэргэшлийн түвшин
1	Төслийн удирдагч	Төслийн багийн удирдагч нь тухайн хотын стандартын баримт бичгийг боловсруулах ажилд судлаачдын бэлтгэсэн шаардлагатай материалд дүн шинжилгээ хийж хотын стандартыг эцэслэн тайлагнах үүргийг гүйцэтгэх бөгөөд архитекторын мэргэжилтэй, төслийн багийг удирдаж байсан туршлагатай, зөвлөх инженерийн зэрэгтэй;
2	Ургамал судлаач	Оршуулгын газрын онцлогт тохирсон модлог ургамлын төлөвлөлт, эгнээ хоорондын зай, арчилгаа, олон улсын стандартыг судлан хотын хэмжээнд даган мөрдөх баримт бичигт тусгах зэрэг ажлыг гүйцэтгэх бөгөөд мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх;
3	Салбарын судлаач	Шарил нутаглуулах зан үйл нь оршуулгын газрын гадна орчинтой хэрхэн холбогдох талаас нь судлан баримт

		материалд дүн шинжилгээ хийж, нэгтгэн боловсруулах үүрэг гүйцэтгэх бөгөөд судалгааны ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх;
4	Хуулийн мэргэжилтэн	Оршуулгын газрын төлөвлөлт, хаалт, нүүлгэн шилжүүлэлтийн шатанд гарч болох хууль эрх зүйн асуудлыг судлан тогтоож заавал даган мөрдөх хэм хэмжээг тогтоосон мэдээллийг баримт бичигт тусгах зэрэг ажлыг гүйцэтгэх ба хуулийн мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх.

ХЯНАСАН:
Байгаль орчны стандартын хэлтсийн дарга /Д.Өлзийсайхан/

БОЛОВСРУУЛСАН:
Байгаль орчны стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Г.Амартүвшин/